

БНХАУ-ЫН ГАНЬСУ МУЖИЙН ТАЛААР ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ

*Н.Төмөр**

БНХАУ-ын Ганьсу муж нь Хятадын баруун хойт бүс нутагт, Хатан голын дээд урсгалын сав газарт орших бөгөөд зүүн талаараа Шэньси муж, өмнө талаараа Сычуань муж, баруун талаараа Хөх-нуур муж, СУӨЗО, хойт талаараа ӨМӨЗО болон манай улсын Говь-Алтай аймагтай хиллэж байдаг. Ганьсу муж бол өнө эртний түүхтэй. Тухайлбал, дорно-өрнийн эдийн засаг худалдааны харилцааг хөгжүүлэхэд нэлээд их үүрэг гүйцэтгэсэн “Торгоны зам”-ын 1600 км зам энэ нутгаар дамжин өнгөрдөг байжээ.¹ Ганьсу мужийн нийт талбайн хэмжээ 455 мян. хавтгай дөр. км, нийт хүн амын тоо 25,62 сая, үүний дотор монгол, төвд, казах, манж, хотон, бао-ан, ту, юйгу, дунсян зэрэг үндэстний цөөнхи оршин амьдарч байгаа бөгөөд тэдний нийт хүн амын тоо 2,184 сая байна.² Ганьсу мужийн баруун урд хэсгийн газар нутагт монголчууд оршин суудаг. 1950 оны 7 дугаар сарын 29-нд Субэй-гийн монгол үндэстний өөртөө засах сянгийг /сянь - засаг захиргааны нэгж/ албан ёсоор байгуулсан. 66,7 мян.хавтгай дөр.км талбайтай, 13 мян. хүн амтай тус нутгийнхан мал аж ахуй голлон эрхлэж, арьс шир боловсруулах, хөдөө аж ахуйн машин механизмыг үйлдвэрлэх үйлдвэрийг нэлээд хөгжүүлэн 2003 оны байдлаар аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээ 315 сая юаньд хүрчээ.³

Ганьсу мужид Ланьчжоу, Цзяюйгуань, Юймэнь, Цзюцюань, Дуньхуан зэрэг Хятадын олон алдартай хотууд байдаг. Тухайлбал, Цзюцюань хотын ойролцоо Хятад Улсын Цзюцюань дахь сансрын нислэгийн төв оршдог бөгөөд энэхүү төвөөс 2003 оны аравдугаар сарын 15-нд Хятадын хүн тээсэн анхны сансрын хөлгийг амжилттай хөөргөжээ.⁴

Ганьсу мужийн төв Ланьчжоу хот бол Хятад улсын нутаг дэвсгэрийн геометрийн төвд оршиж, зуны улиралд бөгчим халуунгүй, өвлийн улиралд тэсгим хүйтэнгүй учир тус хотын дүүргийн газар нутагт газар тариалан, ялангуяа жимсний аж ахуйг хөгжүүлэхэд нэн тааламжтай нөхцөлтэй. Тухайлбал, сүрьеэгийн эмчилгээнд эмийн оронд хэрэглэн, сайн үр дүн өгдөг “Дунголи” хэмээх жимс нь Ланьчжоу хавийн нутагт л ургадаг.⁵

Ланьчжоу хот бол Ганьсу мужийн улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны төв, 3,1 сая хүн амтай орчин үеийн том хот. Хятадын Байгалийн шинжлэх ухааны Академийн эрдэм шинжилгээний олон хүрээлэн Ланьчжоуд ажилладаг. Тухайлбал, Ланьчжоугийн орчин үеийн физикийн хүрээлэнд дэлхийд анх удаа нийлмэл аргаар Hg 208 /мөнгөн

*Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

ус/, Hf (St)185 /Гафний/, Th 237 /Торий/ зэрэг 3 шинэ цөмийн бодис гаргажээ.⁶ Ланьчжоугийн геологи, мөстөл судлал, цөл судлал зэрэг эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд холбогдол бүхий байгууллагын хамт Хятад Улсын газрын тос, байгалийн хийн хайгуул, цөлжилтөөс хамгаалах, орчин үеийн мөстлийг судлах ажилд мөн нэлээд амжилттай үр дүнтэй ажилласаар ирлээ.

Ланьчжоу хотод эдүгээ Ланьчжоугийн их сургууль, Ланьчжоугийн багшийн их сургууль, Ганьсугийн аж үйлдвэрийн их сургууль, Баруун хойт хятадын үндэстний их сургууль, Ланьчжоугийн шинжлэх ухаан техникийн их сургууль зэрэг 31 их дээд сургуультай бөгөөд нийт 60069 оюутан суралцдаг.⁷ Ланьчжоугийн их сургууль 1909 онд байгуулагдаж, одоо 13 дээд сургууль, 9 факультеттай, Хятад улсын томоохон их сургуулиудын нэг нь болжээ. Тус их сургуульд 61 мэргэжлээр бакалавр, 89 мэргэжилээр магистр, 40 мэргэжилээр докторын цол олгож, нийт 23 000 оюутан суралцдагаас 300 нь гадаадын оюутан юм. Ланьчжоугийн их сургууль сургалтыг явуулахаас гадна мөн нийгэм эдийн засаг, хүн ам судлал, геологи, ботаник, биологи, мөстөл, геоэкологи зэрэг олон чиглэлээр судалгааны ажлыг явуулдаг билээ.⁸ Ланьчжоугийн их сургуулийн эрдэм шинжилгээний зарим хүрээлэн Монгол Улсын ШУА-ийн Геологи, эрдэс баялгийн хүрээлэн, Газар зүйн хүрээлэнтэй хамтран ажиллаж, тодорхой төслийг хэрэгжүүлж байгаагаас гадна, тус их сургууль нь Улаанбаатарын их сургуультай мөн хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулан хамтран ажилладаг.⁹ Ланьчжоугийн их сургууль АНУ, Англи, Франц, Канад, Герман, Австрали, Польш, Казахстан зэрэг орны 30 гаруй их дээд сургууль болон эрдэм шинжилгээний байгууллагуудтай харилцаа тогтоож, мэргэжилтэн багш, оюутан, ном сурах бичиг, гарын авлага солилцож, эрдэм шинжилгээний бага хурал хамтран зохиож, гарсан үр дүнг хэвлэн нийтлэх зэргээр гадаад харилцааныхаа үйл ажиллагааг идэвхитэй явуулдаг.

Газар зүйн байршлаар Ганьсу муж Шэньси, Хөх-нуур мужууд ба СУӨЗО, НХҮӨЗО өөртөө засах орнуудын дунд оршиж, зам харилцааны хувьд Баруун-хойт Хятадын төмөр болон авто замын сүлжээний төвд оршино. Тухайлбал, Ланьчжоу хотын төмөр зам нь Цзянсу мужийн Ляньюньган хэмээх далайн боомт хот, СУӨЗО-ны төв Урумчи, ӨМӨЗО-ны Бугат зэрэг томоохон хотуудтай шууд холбогдсон ба Сычуань, Хөх-нуур, Шэньси мужуудын зарим хот суурин газартай мөн төмөр замын харилцаатай.¹⁰ Ганьсу мужаар дамжин өнгөрдөг 36200 км, 72 авто зам нь тус мужийг Хятадын бусад муж, өөртөө засах орнуудтай холбожээ. Ганьсу мужийн хот суурин газар ба хөдөө тосгоны 99,48% нь авто замын сүлжээнд холбогджээ.¹¹ Ганьсу муж нь 40 гаруй агаарын шугамаар Бээжин, Шанхай, Гуанчжоу, Гуйлинь, Чэнду, Си-ань, Урумчи, Харбин,

Шэньянь Гонконг зэрэг Хятадын 37 томоохон хотуудтай шууд харилцаатай байхаас гадна Ланьчжоу хот Москва, Стамбул, Сингапур, Осака, Ванкувер зэрэг хотуудын хооронд өдөр бүр шууд нислэг хийдэг.¹²

Ганьсу муж байгалийн баялгаар нэлээд арвин. Тухайлбал, нийт 1270 төрлийн эмийн ургамал ургадаг нь эмийн ургамалын төрлөөрөө Хятад улсад тэргүүн байр эзэлдэг билээ. Ашигт малтмалаас газрын тос, нүүрс, никель, хар тугалга, цайр, алт, гянтболд зэрэг эрдсийн нөөц ихтэй бөгөөд никель, хар тугалгын олборлолтын хэмжээгээр Хятад Улсад мөн тэргүүн байр эзэлнэ.

Ганьсу мужид дэлхий дахинд алдаршсан эртний торгоны замын чухал хэсэг, Дуньхуангийн Могаоку агуй болон Хятадын Цагаан хэрмийн баруун төгсгөл болох Цзяюйгуань цайз зэрэг түүхийн дурсгалт олон газартай. Торгоны зам гэдэг бол дундад зууны үед европынхон хятадын торго болон бусад эд бараа худалдан авахын тулд Дундад хийгээд Төв Азиар дамжин хүрдэг байсан замыг хэлэх бөгөөд энэхүү замын мянга гаруй км нь Ганьсу мужийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг байлаа. Дуньхуангийн Могаоку агуй нь Дуньхуан хотоос зүүн өмнө тийш 25 км-ийн зайд оршдог бөгөөд дэлхий дахинд алдартай нийт 492 агуйгаас бүрдсэн энэхүү урлагийн эрдэнэсийн санд 366-1368 оны хооронд мянга гаруй жилийн хугацаанд урлан бүтээсэн, 45 мян.ам. дөрвөлжин метрийн ханын зураг болон 3390 өнгөт шуумал хадгалагдсан байдаг. Могаоку агуйн гоё сайхан, амьд мэт дүрсэлсэн эдгээр ханын зургууд нь хятадын ард түмний эртний ахуй амьдралыг тал бүрээс нь тусган харуулжээ. Дуньхуангийн Могаоку агуйг 1989 онд ЮНЕСКО-гийн хамгаалалтанд байлгах дэлхийн чухал соёлын дурсгалт газруудын бүртгэлд оруулсан.¹³ Цзяюйгуань цайз нь Хятадын цагаан хэрмийн баруун төгсгөлийн цэг бөгөөд энэхүү цайзыг Чиляньшань уулархаг цаст нутгийн Цзяюйшань уулан дээр 1372 онд барьж байгуулжээ. Цайзны барилга байгууламж нь уран нарийн, сүр жавхаатай, Ланьчжоу-Урумчийн төмөр зам түүний хажуугаар өнгөрнө. Дээр дурдсан түүхийн дурсгалт газруудаар хятад болон бусад орнуудын жуулчид явах дуртайгаас гадна, түүхч эрдэмтдийн сонирхолыг ихээхэн татдаг.

Ганьсу муж газрын тос, байгалийн хийн арвин нөөцтэй. Тухайлбал, “Юймэнь” газрын тосны орд газар БНХАУ-ын түлш эрчим хүчний асуудлыг шийдвэрлэхэд их үүрэг гүйцэтгэж байсан.¹⁴ Баруун бүс нутгийн байгалийн хийг зүүн бүс нутаг руу дамжуулах явдал нь эрчим хүчээр дутагдаж буй төв болон зүүн бүс нутгийн хөгжилд чухал ач холбогдолтой байхаас гадна төв, зүүн бүс нутагтай харьцуулахад хөгжлөөр нэлээд хоцрогдсон баруун бүс нутгийн хот хөдөөгийн хөгжлийг түргэтгэхэд авч буй нэн шаардлагатай арга хэмжээ билээ.

2000 оны хоёрдугаар сард БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн шийдвэрээр СУӨЗО-ны Таримын байгалийн хийн ордоос Шанхай хот хүртлэх 4000 гаруй км урттай байгалийн хий дамжуулах хоолойг барьж байгуулах болсон.¹⁵ Энэхүү хий дамжуулах хоолой Таримаас Шанхай хүрэхэд Ганьсу муж, НХҮӨЗО, Шэньси, Шаньси, Хэнань, Аньхой, Цзяньсу, Чжэцзянь зэрэг мужуудаар дамжин өнгөрөх учраас тэдгээр мужуудын хөгжилд шууд нөлөөлөх бөгөөд Ганьсу муж хамгийн түрүүнд ашиг тусыг нь хүртэх ба энэ нь газар зүйн байршлаар Таримд хамгийн ойрхон оршдогоор тайлбарлагдана. Энэхүү хий дамжуулах хоолой 2004 оны есдүгээр сард Шэньси мужийн Цзиньбянь хэмээх газарт нэгэнт хүрчээ.¹⁶ Байгалийн хийн хоолойг барьж байгуулснаар Таримын байгалийн хийн нөөц баялагийг ашиглах боломжтой болж, дээр дурдсан өөртөө засах орон, мужуудыг эрчим хүчээр хангахаас гадна эдгээр мужуудын хар төмөрлөг, цемент, машин механизмын үйлдвэрийг хөгжүүлэхэд ч эерэг нөлөө үзүүлэх юм. Тарим-Шанхайн байгалийн хий дамжуулах хоолой нь жилд 20 тэрбум шоо дөр.метрийн хий дамжуулах хүчин чадалтай бөгөөд энэ нь 20 сая. тн газрын тос буюу 26,6 сая. тн нүүрстэй тэнцдэг гэсэн тооцоо гарч байгаа ба ийм хэмжээний түлш шатхуунаар 100 тэрбум кв/цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж болох юм.

Таримын байгалийн хийн орд газрын нийт нөөц нь 567,9 тэрбум шоо дөр. метр бөгөөд Ганьсу, Шэньси мужууд, НХҮӨЗО, Цайдамын хотгор зэрэг бусад орд газрын байгалийн хийн нөөцтэй нийлүүлэн Хятадын Баруун бүс нутагт 1999 оны байдлаар нийт 1500 тэрбум шоо дөр. метрийн байгалийн хийн нөөцтэй.¹⁷ Байгалийн хийг ашиглах зорилгоор Хятадын Баруун бүс нутагт орших Урумчи, Корла, Цзепу, Дуньхуан, Иньчуань, Сянь-янь, Юйлинь, Пэнчжоу зэрэг 8 хот суурин газарт байгалийн хийг боловсруулах химийн үйлдвэрийг байгуулж ажиллуулах болсон нь эдгээр газар нутгийн ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг арилгах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд их үүрэг гүйцэтгэхээс гадна тус бүс нутгийн экологийн байдлыг сайжруулахад мөн чухал ач холбогдолтой. Учир нь үүнээс өмнө байгалийн хийн оронд нүүрс, мод зэрэг түлшийг шатааж байгаль орчныг ихээхэн бохирдуулж, маш их хэмжээний ой модыг сүйтгэж байжээ. Ганьсу мужийн нутгаар дамжин өнгөрөх Баруун бүс нутгийн хийг Зүүн бүс нутаг руу дамжуулах болсон явдал нь тус мужийн эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

ТАЙЛБАР, ЗҮҮЛТ:

1. “Хятад улсын Баруун бүс нутаг - Ганьсу муж” /Чжунго сибу - Ганьсу/, Бээжин, 2001, 13 дахь тал., “Үгсийн далай” /Цыхай/, Шанхай, 1983, 53 дахь тал.
2. “Хятад улсын Баруун бүс нутаг - Ганьсу муж” /Чжунго сибу - Ганьсу/, Бээжин, 2001, 15-18, 23 дахь тал.
3. “Ганьсу мужийн оны лавлах бичиг” /Ганьсу няньцзянь/ - 2004, Бээжин, 2004, 178-179 дэх тал.
4. “Beijing Review”, 2003, No 43, pp. 4-7, No 46, pp.10-17; “Солонго”, сэтгүүл, 2003, №11, 6-9 дэх тал; “Өдрийн сонин”, 2003.10.9, 15, 16.
5. “Хятад улсын Баруун бүс нутаг-Ганьсу муж” /Чжунго сибу - Ганьсу/, Бээжин, 2001, 12, 99 дэх тал.
6. Мөн ном, 48 дахь тал.
7. “Ганьсу мужийн оны лавлах бичиг” /Ганьсу няньцзянь/ - 2004, Бээжин, 2004, 112 дэх тал.
8. “Хятад улсын Баруун бүс нутаг - Ганьсу муж” /Чжунго сибу - Ганьсу/, Бээжин, 2001, 47-49 дэх тал., “Үгсийн далай” /Цыхай/, Шанхай, 2000, 343-344 дэх тал.
9. “Mongolia Academy of Sciences”, UB, 2001, p.77
10. “Китай-2003”, Пекин, 2003, стр. 170., “Хятад улсын Баруун бүс нутаг-Ганьсу муж” /Чжунго сибу-Ганьсу/, Бээжин, 2001, 63 дахь тал.
11. “Хятад улсын Баруун бүс нутаг-Ганьсу муж” /Чжунго сибу - Ганьсу/, Бээжин, 2001, 62 дахь тал.
12. “Time table Air China”, 2004, Summer-Autumn, p. 77
13. “Хятад улсын Баруун бүс нутаг-Ганьсу муж” /Чжунго сибу - Ганьсу/, Бээжин, 2001, 93 дахь тал., “Үгсийн далай” /Цыхай/, Шанхай, 2000, 741 дэх тал.
14. Ли Шаньтун. Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх ба орон нутгийн хамтын хөгжил /Сибу да кайфа юй дишой сетяо фачжань/, Бээжин, 2003, 517 дахь тал., “Үгсийн далай” /Цыхай/, Шанхай, 2000, 1960 дахь тал.
15. Zhang Zhongyuan. Questions and Answers on West China, Chengdu, 2001, p. 278
16. “Жэньминь жибао”, сонин, 2004.09.07
17. Zhang Zhongyuan. Questions and Answers on West China, Chengdu, 2001, p. 297